



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/86/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	М.Дүүрэнжаргал
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.08.24 № 1-6/65

танай _____ -ны № _____ -т

УЛААНБАДРАХ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
ДАРГА А.МӨНХЦАЦРАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанбадрах сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

010020010

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1.2	3.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2.2	28.4
	Нийт хөрөнгийн дүн	3.4	31.4
	Нийт өр төлбөрийн дүн	0.6	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2.8	31.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3.4	31.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	66.0	113.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	66.9	85.2
	Үйл ажиллагааны үр дүн	(0.9)	28.6
	Үйл ажиллагааны бус үр дүн	(0.1)	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(1.0)	28.6
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	(0.9)	28.6
	Эцсийн үлдэгдэл	2.7	31.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	66.0	75.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	65.5	75.6
	Үйл ажиллагааны ЦМГ	0.5	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	0.5	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	65.7	71.5
	Урсгал зардал	65.7	71.5
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	65.7	71.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	65.7	71.5

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тайлант онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлыг иргэдийн нийтлэг эрх ашигт тулгуурлан шийдвэрлэж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгын хүрээнд зорилго тавьж, ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсөвт байгууллага нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын жишиг нормоос хэтрүүлсэн зарцуулсан бөгөөд бодит гүйцэтгэлийг илэрхийлэх шатахууны норм баталсан тушаал үйлдээгүй байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49.4 сая төгрөгийн 7 орлогын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 21.1 сая төгрөгийн 33 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.4 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээг, 2.9 сая төгрөгийн 4 тушаалыг огт байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан талаарх асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 7.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7.0 сая төгрөгийн алдааг залруулж, бусад зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

1. Ерөнхий журналас зардлын данс тус бүрээр шүүж үзэхэд 2 дансны 0.7 сая төгрөгийн 9 гүйлгээг буруу зардалд бүртгэсэн байна.
2. Ерөнхий журналас санхүүжилтийн орлогыг шүүхэд 71.5 сая төгрөгийг бүртгэсэн бол шалгадагч байгууллагын үндсэн дансны хуулгыг шүүхэд 77.8 сая төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байсныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж:

1. Шалгадагч байгууллага нь Ланд-200 маркийн авто-тээврийн хэрэгслийг балансаас шилжүүлэн авсан бөгөөд тус тээврийн хэрэгслийн шатахууны зарцуулалтыг 2019 оны 12 дугаар сарын 30-ны Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 тушаалын жишиг нормд 8.4л/100км байхаар зааж өгсөн байна. Харин тус байгууллагын жолоочийн тооцооноос үзэхэд 21.5л/100 км-н шатахууны зарцуулалттай байна.
2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 38 нэр төрлийн 5.4 сая төгрөгийн хөрөнгө байна.

Албан шаардлага:

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч баримтжуулж, баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчиж, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	5	7.0	2	7.0	-	-	1	-	2	-
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	5	7.0	2	7.0	-	-	1	-	2	-